**Техникийн тодорхойлолт**

Толгой, нүүр хамгаалах хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага

| Д/Д | Материалын нэр | Техникийн үзүүлэлт | Зориулалт | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Дуулга /КАСКА/ | MNS 5621-2006 ISO, EN397, ISO EN50365 стандарт болон дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:<br>1.Механик үйлчлэлээс хамгаалах чадвар: 5 кг-ийн хагас бөмбөрцөг хэлбэртэй ачааг 1 м өндрөөс унагаж туршсан байна.<br>2.Цахилгаан гүйдлээс хамгаалах чадвар 1000В хүртэл<br>3.Температурын горим: -30$^0$С-:-+40$^0$С<br>4.Дуулгын их бие:полиэтилен болон полипропиленээр (polypropylene, polyethelene ) хийгдсэн байна.<br>5.Толгойн оройноос хөндийрүүлэх татуурга: 3ш байх ба дуулганд 6 цэгээр холбогдоно.<br>6.Дуулга нь бүчтэй байх бөгөөд чихний 2 талаар орж эрүүвчлэгддэг байна.<br>7.Хөлс шингээгчтэй байна.<br>8.Толгойд бэхлэгдэх хэсэг нь хэмжээг тохируулах тохируулгатай байна.<br>9.Каскны ар болон хажуу талаас харагдахаар гэрэл ойлгогчтой байна. (5 см өргөнтэй туузан)<br><br>Шар, цагаан, улаан өнгөтэй /тоо ширхэгийг захиалгаас харна уу/. | Толгойг механик, дулааны, цахилгааны үйлчлэлээс хамгаална. | Нэгээс доошгүй агаар сэлгэлттэй байвал сайн. Толгой<br>хамгаалах хэрэгслийн техникийн бичиг баримт, эрх бүхий байгууллагаар баталгаажсан зөвшөөрөл, хамгаалах<br>хэрэгсэл гурав хоорондоо тохирсон байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Хатуулгатай саравчтай малгай<br>/САРАВЧТАЙ МАЛГАЙ/ | 1. ISO EN812 стандарт болон дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:<br>2. Малгайны материал:хөвөн даавуу-80%, полиестер-20% байна.<br>3. Малгайн гадар болон дотор хэсэг агаар орох, агаар сэлгэх боломжтой /чийг татахгүй, хөлөргөхгүй/ байна.<br>4. Толгойны гадаргуутай харьцах хэсэг нь арьс цочроохгүй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй.<br>5. Малгайны чангалах, суллах тохиргоо нь дагзны хэсэгт байрлалтай.<br>6. Хамгаалалт малгайнаас салдаг, малгай болон хатуулгыг угааж цэвэрлэх боломжтой.<br>7. Хар хөх өнгөтэй.<br>8. “УБЦТС” ТӨХК-ийн логотой байх ба малгайны гадна хэсэгт байрлуулсан байна. | Өндрийн өөр<br>түвшинд ажил гүйцэтгэдэггүй ажлын байранд өмсөнө. | Тендерт шалгарсан тохиолдолд логоо хэмжээ байршлыг зөвшилцөнө. |
| 3 | Цахилгаан нумнаас хамгаалсан нүүрэвч | ISO EN166 стандарт болон дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:<br>1. Нүүрэвчний харааны зэрэг: 1 буюу хараанд өөрчлөлт өгөхгүй байх<br>2. Зурагдах, зүсэгдэхээс хамгаалагдсан байна.<br>3. Линзний зузаан 1,2мм-ээс багагүй байна.<br>4. Нүүрэвчний материал: поликарбонатаар хийгдсэн байна.<br>5. Нүүрэвчний өндөр нь 240мм-ээс багагүй байна.<br>6. Дуулганд бэхлэх боломжтой, дуулганд бэхлэгдэхдээ нумарсан байдлаар бэхлэгдэнэ.<br>7. Ультра ягаан туяаны шүүлтүүртэй /3/, гэрэл шүүх чадвар-1,2 химийн бодис /3/ болон цахилгаан нумнаас хамгаалсан /8/35кВ хүртэл<br>8. Металл хийц ороогүй | Цахилгаан тоноглолд сэлгэн залгалт хийх үед хэрэглэнэ. | Нүүрэвчний техникийн бичиг баримт, эрх бүхий<br>байгууллагаар баталгаажсан<br>зөвшөөрөл, нүүрэвч гурав<br>хоорондоо тохирсон байна. |

| Д/ | Материалын нэр | Техникийн үзүүлэлт | Зориулалт | Тайлбар |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл /Тоосноос хамгаалах/ | MNS 5620-2006 Амьсгалын замын хамгаалалтын хэрэслийн норм EN 149, 146,141, 140, 143, 148 стандарт нормын шаардлагыг хангасан байна.<br>Үүнд:<br>1.Хамгаалах чадвар FFP-2 үзүүлэлтийг хангасан байх / MNS5620-2006 8.2.1.1/<br>2.Тоосноос хамгаалах шүүгчийн давхар нь 10 ба түүнээс дээш байх<br>3.Амьсгал гаргах хавхлаг / клапан/-тай байх<br>4.Хамрын хянганы даруулга төмөр тохируулагчтай байх<br>5.Толгойд бэхлэх 2 резинэн уяатай байх<br>6. Хөлөргөхгүй, харшлахгүй ,амьсгалахад саадгүй ,чөлөөтэй байх<br>7. Хөнгөн уян хатан, хүний нүүрний хэлбэрт зохицсон байх | Амьсгал хамгаалах хэрэгсэл нь үйлдвэрийн тоос, химийн бодис, утаа угаар,болон хорт хийн бүтээгдэхүүнээс амьсгалын замын эрхтэнийг хамгаалах зориулалтын хэрэгсэл. | |

Нийлүүлэгдэх барааны хувьд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалт хангаж байгаа эсэхийг техникийн үзүүлэлт бүрээр нотолсон үйлдвэрийн баримт /техникийн өгөгдөл буюу паспорт/, холбоо барих хаяг, и-майл хаягийг ирүүлнэ.

Тендерт оролцогч нь санал болгож буй барааны загварыг тендер нээхээс өмнө авчирч өгсөн байх шаардлагатай. / Загвар ирүүлээгүй тохиолодолд тендерээс татгалзах үндэслэл болно.

Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд барааг буцаах ба тус барааг сольж өгнө. Үүнтэй холбоотой гарах зардлыг захиалагч тал хариуцахгүй.

ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС